



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ТАЙЛАНТ ОНД АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫГ БОДИТОЙ
ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС НИЙТ ТАТВАРЫН ОРЛОГО 24.2 ХУВИАР ТАСАРСАН БАЙНА.

АУДИТЫН КОД: ОРА-2026/02-13/НА-СТА-НТГ



Эрдэнэт хот
2026

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

**Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
П.Пүрэвлхагва**
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор Г.Даваасүрэн
Утас: 70350757 Цахим хаяг: davaasureng@audit.gov.mn



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/07

Баян-Өндөр сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн дөрөвдүгээр хавсралт 1.4, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орхон аймгийн Засаг даргын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл"-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Д.Мөнхбат, аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр нарт хүргүүлэхийг аудитор (Г.Даваасүрэн)-д даалгасугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2027 оны 04 сарын 01-ний дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр, санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ш.Өлзийбаяр нарт зөвлөсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Буян-Ундрах/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Я.ПҮРЭВЛХАГВА



612501012

Агуулга

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	4
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	4
Аудитын зорилт:	4
Аудитын хамарсан хүрээ:	4
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:.....	4
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:.....	5
1. ОРХОН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ХУВИАР ТАСАРСАН БАЙНА.	15
1.1 Аймгийн төсөвт 1 удаа тодотгол хийж, орлогыг анх батлагдсан дүнгээс 4,191.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, баталсан байна.....	6
1.2 Тайлант онд аж ахуйн нэгжийн болон зарим татварын орлогыг бодитой төлөвлөөгүйгээс нийт татварын орлого 24.2 хувиар тасарсан байна.....	7
1.3 Орхон аймгийн Засаг дарга “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2024 оны дутуу санхүүжилт тайлант онд Эрдэнэт сангийн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой татварын бус орлого 68.9 хувиар давж биелсэн байна.....	9
2. АЙМГИЙН НИЙТ ОРЛОГО ТАЙЛАНТ ОНД ТАСАРСНААС НИЙТ ЗАРДАЛ 43.8 ХУВИАР ДУТУУ ХЭРЭГЖСЭН БАЙНА.	10
2.1 Орхон аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн зардлын хэрэгжилт 56.2 хувьтай байна.....	10
2.2 Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	13
3. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРСЭН ҮР ДҮН, ТҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГЫГ ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.....	14
3.1 Аймгийн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний биелэлт 83.5 хувьтай хэрэгжилт хангажээ.....	14
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хөтөлбөр арга хэмжээний хүрсэн үр дүн түүний танилцуулгыг тайлагнаагүй байна.....	15
4. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙГ ХУГАЦААНААС НЬ ӨМНӨ ТӨЛЖ, АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАН АЖИЛЛАСАН БАЙНА. 17	
4.1“Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламж”-ийн өргөтгөлийн төслийн зээлийг хугацаанаас өмнө төлж дуусгасан байна.....	17
4.2 Өмнөх оны аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.....	17
АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	18
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын их хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХО	Хөрөнгө оруулалт
ТБОНӨБХБ	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗСБҮА	Зөвлөх сонгох бага үнийн арга
ОНОХА	Олон нийтийн оролцоог хангах арга
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ДТС	Дулаан түгээх сүлжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ОХНС	Орон нутгийн хөгжлийн сан
АЗС	Авто замын сан
ТАХ	Төсөл арга хэмжээ

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутгийн төсвийн орлогын аймгийн ИТХ-аар батлагдсан төсөв	4
Хүснэгт 2	Орон нутгийн татварын орлогын биелэлт	5
Хүснэгт 3	Орон нутгийн татварын бус орлогын биелэлт	7
Хүснэгт 4	Орон нутгийн төсвийн зардал баталсан байдал /Аймаг/	8
Хүснэгт 5	Орон нутгийн төсвийн зардал, тодотгол /Баян-өндөр сум/	8
Хүснэгт 6	Орон нутгийн төсвийн зардал, тодотгол /Жаргалант сум/	9
Хүснэгт 7	2025 оны төсвийн зарлагын гүйцэтгэл	9
Хүснэгт 8	Орон нутгийн төсвийн байгууллагын албан хаагчдын тоог 2024, 2025 онтой харьцуулсан байдал	12
Хүснэгт 9	Нэмэлт санхүүжилтийн зардлын гүйцэтгэл	13
Хүснэгт 10	ОНХО-ын зардлын төлөвлөлт /аймаг/	14
Хүснэгт 11	ОНХО-ын зардлын төлөвлөлт /Баян-Өндөр, Жаргалант сум/	14
Хүснэгт 12	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл	14,15
Хүснэгт 13	Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл	15
Хүснэгт 14	Аудитын зөвлөмжийн хэрэгжилт	16

ГРАФИКИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Тайлант оны татварын орлогын биелэлтийн хувь	6
График 2	Улсын төсвийн захиргааны байгууллагын албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл	11

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2025 оны А/179 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

- Орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөж, орлогын төлөвлөгөөний биелэлт хангагдсан эсэх.
- Орон нутгийн төсвийн зарлагыг бодитой төлөвлөж, төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх.
- Хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэл хангагдсан эсэх.
- Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, өмнөх оны аудитын зөвлөмжийн биелэлт хангагдсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Сангийн яамнаас Орхон аймгийн 2025 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянасан дүн, тооцоолол, аймгийн Татварын хэлтсийн дүн, мэдээ зэрэг баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”, 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,

- Төсвийн тухай хууль ,
- Төрийн аудитын тухай хууль,
- Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Татварын багц хуулиуд,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолууд,
- Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны “Ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмж батлах тухай” А/111 дүгээр тушаал,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвхажва удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Г.Даваасүрэн 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, аймгийн ИТХ-ын тогтоолоор төсөвт 1 удаа тодотгол хийж, татварын орлогыг 26,118.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, татварын бус орлогыг 2,419.1 сая төгрөг, тусламжийн орлогыг 19,507.3 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Тайлант онд 2025 оны нийт орлогыг 401,441.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 341,163.0 сая төгрөг буюу 15 хувиар тасарчээ. Үүнээс татварын орлогыг 241,748.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 245,965.0 сая төгрөг буюу 1.7 хувиар давж биелсэн байна.

Аймгийн төсвийн нийт зарлагыг 369,208.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр урсгал зардалд 214,707.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 101,704.5 сая төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 250.8 сая төгрөг, нийт 316,663.2 сая төгрөг зарцуулж, 80.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд 2024 оны төсвийн жилд Орхон аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 137,661.3 сая төгрөгөөр, 18 дугаар зүйлд орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 34,710.3 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

1. ОРХОН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН ОРЛОГО 15 ХУВИАР ТАСАРСАН БАЙНА.

1.1 Аймгийн төсөвт 1 удаа тодотгол хийж, орлогыг анх батлагдсан дүнгээс 4,191.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, баталсан байна.

Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг Сангийн сайдын 2012 оны 244 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын дагуу боловсруулан нийт орлогыг 294,322.5 сая төгрөг байхаар санал өгсөнийг Сангийн яамнаас 148,3974.6 сая төгрөгөөр хянасаны дотор аж ахйн нэгжийн татварын орлогыг 165,000.0 сая төгрөгөөр санал өгснийг хянаагүй байна.

Орон нутгийн төсвийн орлогыг Баян-Өндөр сум 167,280.7 сая төгрөг, Жарглант сум 19,208.2 сая төгрөг, аймаг 223,838.4 сая төгрөг нийт 410,327.3 сая төгрөгийг бүрдүүлэхээр баталжээ.

Хүснэгт №1 Орон нутгийн төсвийн орлогын аймгийн ИТХ-аар батлагдсан төсөв

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Аймгийн ИТХ 03/13 тогтоол	Аймгийн ИТХ 03/40 тогтоол	Зөрүү
Урсгал орлого	193,539.2	217,238.1	23,698.9
Татварын орлого	183,300.0	209,418.1	26,118.1
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	180,000.0	206,118.1	26,118.1
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,500.0	1,500.0	0.0
Улсын тэмдэгтийн хураамж	1,000.0	1,000.0	0.0
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	800.0	800.0	0.0
Татварын бус орлого	10,239.2	7,820.1	-2,419.1
Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,457.1	3800.0	1,342.9
Хүү, торгуулийн орлого	1,800.0	1,850.0	50.0
Түрээсийн орлого	732.1	732.1	0.0
Орон нутгийн өмчийн эд хөрөнгө борлуулсны орлого	5,200.0	5,200.0	0.0
Тусламжийн орлого	157,507.5	138,000.2	-19,507.3
Хандив тусламжийн орлого	4,000.0	2,100.0	-1,900.0
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	38,727.7	26,251.7	-12,476.0
Баян-Өндөр сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого	114,779.8	109,648.5	-5,131.3
Урьд оны шилжих үлдэгдэл	55,089.0	55,089.0	0.0
Урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжих	21,101.1	21,101.1	0.0
Урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжих /ОНХС/	33,987.9	33,987.9	0.0
Нийт дүн	406,135.6	410,327.3	4,191.7

Аймгийн 2025 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн ээлжит бус III хуралдааны 03/13 дугаар тогтоолоор нийт орлогыг 406,135.60 сая төгрөгөөр баталсныг 2025 оны 07 дугаар сарын 09-ний 03/40 дүгээр тогтоолоор 410,327.30 сая төгрөг буюу 4,191.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ.

1.2 Тайлант онд аж ахуйн нэгжийн болон зарим татварын орлогыг бодитой төлөвлөөгүйгээс нийт татварын орлого 24.2 хувиар тасарсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн татварын орлогын гүйцэтгэл 75.8 хувь буюу 87,665.7 сая төгрөгөөр дутуу биелсэн байна.

Хүснэгт №2 Орон нутгийн татварын орлогын биелэлт

/сая төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны гүйцэтгэл	Төвлөлгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Нийт татварын орлого	245,964.9	361,668.2	274,002.5	(87,665.7)	75.8
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	78,291.7	85,735.2	83,069.4	(2,665.8)	96.9
2	Үйл ажиллагааны орлого	884.9	810.0	995.0	185.0	122.8
3	Хөрөнгийн орлого	4,099.2	6,152.0	4,886.7	(1,265.3)	79.4
4	Хөрөнгө борлуулсны орлого	5,103.6	4,040.0	4,631.9	591.9	114.7
5	Шууд бус орлого	5,600.9	4,060.1	2,663.2	1,396.9	65.6
6	ХХОАТ-ын буцаалт	- 5,118.3	- 5,393.3	- 5,393.3	0	100.0
7	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	100,000.0	206,118.0	102,135.7	(103,982.3)	49.6
8	Үл хөдлөх хөрөнгийн татвар	22,010.9	23,378.4	24,387.1	1,008.8	104.3
9	Бууны татвар	54.9	48.0	50.7	2.7	105.6
10	АТБӨЯХАТатвар	1,389.0	1,500.0	1,658.7	158.7	110.6
11	Малд ногдуулах албан татвар	57.6	34.4	95.2	60.9	277.2
12	Улсын тэмдэгтийн хураамж	1,096.7	1,090.5	1,072.8	(17.7)	98.4
13	Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогын албан татвар	65.7	47.0	103.0	56.0	219.2
14	Хог хаягдлын хураамж	2,087.1	1,740.0	2,150.6	410.6	123.6
15	Бусад татвар	1,290.7	-	19,253.5	19,253.5	
16	Газрын төлбөр	27,088.6	31,505.1	31,228.0	(277.1)	99.1
17	Газрын дуудлага худалдаа	897.7	-	2,314.7	2,314.7	
18	Ойн нөөц ашигласны төлбөр	1.7	1.4	1.6	0.1	109.3
19	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	1,062.4	801.5	1,012.8	211.3	126.4

Орон нутгийн төсөвт төвлөрөх 2025 оны татварын орлогыг 361,668.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 274,002.5 сая төгрөг төвлөрч, 87,665.7 сая төгрөг буюу 24.2 хувиар орлогын төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг бодитой төлөвлөөгүйгээс шалтгаалжээ.

Татварын орлогын төлөвлөгөө биелээгүй нэр төрлөөр нь авч үзвэл:


- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 206,118.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 102,135.7 сая төгрөг буюу 103,982.3 сая төгрөг дутуу,
- Хөрөнгийн орлого 6,152.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 4,882.7 сая төгрөг буюу 1,265.3 сая төгрөг дутуу,
- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын татвар 85,735.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 83,069.4 сая төгрөг буюу 2,665.8 сая төгрөг дутуу,
- Улсын тэмдэгтийн хураамж 1,096.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,090.5 сая төгрөг буюу 17.7 сая төгрөг дутуу,

- Газрын төлбөр 31,505.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 31,228.0 сая төгрөг буюу 277.1 сая төгрөг дутуу төвлөрүүлжээ.

ТЕЗ-ийн 2025 оны эхний хагас жилийн байдлаар аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 43,282.1 сая төгрөг буюу 24 хувийн гүйцэтгэлтэй байхад Аймгийн ИТХ-ийн 2025 оны 07 сарын 09-ны өдрийн 03/40 дүгээр тогтоолоор тодотгол хийж, 26,118.0 сая төгрөгөөр нэмж баталнаас шалгаалж орон нутгийн төсөвт төвлөрөх 2025 оны татварын орлогын төлөвлөгөө 24.2 хувиар тасарсан байна.

Бусад татвар ангилалд татварын хяналт шалгалтаар илрүүлсэн томоохон татвар төлөгчдийн төлбөл зохих 19,253.5 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэнтэй холбоотой татварын орлогын бүрдүүлэлтэд эерэгээр нөлөөлжээ.

График № 1 Тайлант оны татварын орлогын биелэлтийн хувь



Дээрх графикаас харахад татварын орлогыг тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөөгүй нь харагдаж байна.

1.3 Орхон аймгийн Засаг дарга “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2024 оны дутуу санхүүжилт тайлант онд Эрдэнэт сангийн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой татварын бус орлого 68.9 хувиар давж биелсэн байна.

Татварын бус орлогыг 39,773.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 67,160.5 сая төгрөг төвлөрч, 27,387.3 сая төгрөгөөр орлого давж биелсэн байна.

Хүснэгт №3 Орон нутгийн татварын бус орлогын биелэлт

/сая төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Нийт татварын бус орлого	65,487.8	39,773.3	67,160.5	27,387.3	168.9
1	Торгуулийн орлого	2,302.7	2,170.0	3,078.7	908.7	141.9
2	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	26,167.4	5,419.5	30,534.9	25,115.4	563.4
3	Түрээсийн орлого	945.3	732.1	754.6	22.4	103.1
4	Бусад орлого	390.4	-	734.4	734.4	
5	Хөрөнгийн орлого /ТБОНӨБХБ/	2,192.7	5,200.0	5,883.9	683.9	113.1
6	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	33,480.2	26,251.7	26,174.1	(77.6)	99.7

Татварын бус орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 25,714.5 сая төгрөгөөр бууруулан 39,773.3 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 5,419.5 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 30,534.9 сая төгрөгийг төвлөрүүлж, 25,115.4 сая төгрөгийн орлого давж биелсэн байна. Энэ нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хамтран ажиллах гэрээний дагуу авто замын санхүүжилт 50,000.0 сая төгрөг батлагдсанаас 2024 онд санхүүжилтийг дутуу хүлээн авсан бөгөөд, 2025 онд үлдсэн санхүүжилт болох 26,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсантай холбоотой төсөвт байгууллагын өөрийн орлого нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төрийн орон сууцны корпорацад төлөх 315 айлын орон сууцны төлбөрийн маргаантай холбоотой нийт орсон 2,809.6 сая төгрөгийн орлогоос 560.6 сая төгрөгийг Монгол улсын хөгжлийн банканд төлж, үлдэх 2,249.0 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогын гүйцэтгэл 13.1 хувиар давж биелсэн байна.

2. АЙМГИЙН НИЙТ ОРЛОГО ТАЙЛАНТ ОНД ТАСАРСНААС НИЙТ ЗАРДАЛ 43.8 ХУВИАР ДУТУУ ХЭРЭГЖСЭН БАЙНА.

2.1 Орхон аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн зардлын хэрэгжилт 56.2 хувьтай байна.

Хүснэгт №4 Орон нутгийн төсвийн зардал баталсан байдал /Аймаг/

№	Зарцуулах эрх, эх үүсвэр	/сая төгрөг/		
		Аймгийн ИТХ 03/13 тогтоол /2024.12/	Аймгийн ИТХ 03/40 тогтоол /2025.07/	Зөрүү /өсөлт +бууралт-/
1	Орон нутгийн төсвийн байгууллага	36,592.8	39,560.3	2,967.5
2	Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	8,456.7	8,606.7	150.0
3	Хөрөнгө оруулалт	181,725.4	228,317.8	46,592.4
4	Орон нутгийн хөгжлийн сан /сумдын/	23,280.8	14,609.1	(8,671.7)
5	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээний ашиглалтын зардал	8,057.5	8,057.5	0.0
6	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	145,266.8	108,420.3	(36,846.5)
7	Дамжуулан зээлийн эргэн төлөлт	2,755.6	2,755.6	0.0
	Дүн	406,135.6	410,327.3	4,191.7

Аймгийн 2025 оны төсвийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/13 дугаар тогтоолоор 406,135.6 сая төгрөгөөр баталж 2025 оны 07 дүгээр сарын 09-ний өдрийн 03/40 дугаар тогтоолоор 410,327.3 сая төгрөг болгон 4,191.7 сая төгрөгөөр бууруулан 1 удаа тодотгосон байна.

Хүснэгт №5 Орон нутгийн төсвийн зардал, тодотгол /Баян-өндөр сум/

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	/сая төгрөг/		
		Баян-Өндөр сумын ИТХ-ын 2024.12.31 №17	Баян-Өндөр сумын ИТХ 39 тогтоол 2025.07 сар	Зөрүү /өсөлт +бууралт-/
1	Орон нутгийн төсвийн байгууллага	27,649.8	27,593.4	- 56.4
2	Хөрөнгө оруулалт	8,843.4	16,878.7	8,035.3
4	Сумын орон нутгийн хөгжлийн сан	16,236.7	12,157.1	- 4,079.6
5	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал	1,002.9	1,002.9	0
6	Төсөвт төвлөрүүлэх орлого	114,779.8	109,648.5	- 5,131.3
	Нийт дүн	168,512.6	167,280.6	-1,232.0

Баян-Өндөр сумын 2025 оны баталсан төсвийг 1 удаа тодотгон 1,232.0 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Хүснэгт№6 Орон нутгийн төсвийн зардал, тодотгол /Жаргалант сум/

/сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Жаргалант сумын ИТХ-ын 2024.12.31 №02/31	Жаргалант сумын ИТХ-ын 2025.07.23 №02/10	Зөрүү /өсөлт+, бууралт-/
1	Орон нутгийн төсвийн байгууллага	5,184.9	5,113.5	- 71.4
2	Хөрөнгө оруулалт	7,167.7	7,325.8	158.1
4	Сумын орон нутгийн хөгжлийн сан	12,261.6	6,638.1	- 5,623.5
5	Хоршоог хөгжүүлэх сан	130.8	130.8	0
	Нийт дүн	24,745.1	19,208.2	- 5,536.9

Жаргалант сумын 2025 оны баталсан төсвийг 1 удаа тодотгон 5,536.9 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Орхон аймгийн Засаг даргын 2024 оны нийт зардлыг 468,108.3 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 262,844.7 сая төгрөг зарцуулжээ.

Тайлант оны гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлээс 53,818.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт№7 2025 оны төсвийн зарлагын гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	2024 он	2025 он		Биелэлт	
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл	30,357.9	33,456.4	29,275.2	4,181.2	87.5
2	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,506.6	8,965.8	6,283.5	2,682.4	70.1
3	Хангамж, бараа материалын зардал	3,128.3	4,543.8	3,949.7	594.1	86.9
4	Норматив зардал	212.4	343.9	301.9	42.1	87.8
5	Эд хогшил, урсгал засварын зардал	3,701.5	4,765.8	3,917.6	848.1	82.2
6	Томилолт, зочны зардал	308.7	733.6	572.3	161.2	78.0
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,935.2	30,865.9	21,932.6	8,933.4	71.1
8	Бараа үйлчилгээний бусад зардал	1,575.6	3,253.8	2,683.6	570.3	82.5
9	Хүү	2,956.8	2,755.61	2,344.7	410.9	85.1
10	Татаас, урсгал шилжүүлэг	142,024.9	128,333.3	42,208.9	86,124.4	33.0
11	Хөрөнгийн зардал	101,704.6	249,312.5	148,952.0	100,360.5	59.7
12	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	250.7	777.8	422.7	355.1	54.3
	Нийт дүн	316,663.20	468,108.30	262,844.72	205,263.58	56.15

Орхон аймгийн Засаг даргын 2025 оны нэгдсэн төсвийн нийт зарлага 262,844.7 сая төгрөг буюу 56.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 83,000.0 сая төгрөгийг төвлөрүүлээгүй нь голлох нөлөө үзүүлжээ.


Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын ангиллаас гадаад арга хэмжээний зардлыг зарцуулсан байна. Тус зардлыг батлагдсан хөтөлбөр, хүрэх үр дүнтэй уялдуулалгүй өмнөх оноос 1.9 дахин өсгөн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41.1-

д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ." Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ын 5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтад заасны дагуу 2025 онд Улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл 15,316.3 сая төгрөг олгох төсвийг баталжээ.

График№2 Улсын төсвийн захиргааны байгууллагын албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл

/сая төгрөг/



Орон нутгийн төсвөөс олгож буй орон нутагт ажилласны нэмэгдлийг 2023 онд улсын төсвийн 17 байгууллагад 1,024.1 сая төгрөг, 2024 онд 85 байгууллагад 6,470.8 сая төгрөг, 2025 онд 85 байгууллагад 13,665.6 сая төгрөгийг санхүүжилтийг тус тус олгожээ.

Засаг даргын төсөл хөтөлбөрийн зардлаас олгодог орон нутагт ажилласны нэмэгдэл цалин тайлант онд гүйцэтгэлээр 85 төсвийн шууд захирагчийн 13,665.6 сая төгрөгийн санхүүжилтээс 43 байгууллагын 226.0 сая төгрөгийн хэмнэлтийг орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна. Тус нэмэгдэл цалинг олгосон санхүүжилтийг жилийн эцсээр тооцоо нийлж баталгаажуулаагүйн улмаас 24 төсвийн шууд захирагчийн 82.0 сая төгрөгийн хэрэглээгүй үлдэгдлийг орон нутгийн дансанд төвлөрүүлэлгүй улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

Орхон аймгийн Архивын хэлтэс 2025 оны 08 сард шинээр байгуулагдсан, Хот байгуулалт, барилга захиалагчийн алба нь аймгийн ИТХ-ын 03 сарын 02/21 дугаартай тогтоолоор ОНӨААТҮГ -аас УТҮГ болж өмчийн хэлбэр өөрчлөгдсөн байна.

Хүснэгт№8 Орон нутгийн төсвийн байгууллагын албан хаагчдын тоог 2024, 2025 онтой харьцуулсан байдал

№	Нэр төрөл	2024 он	2025 он	Зөрүү
1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	16	18	2
2	Төсвийн байгууллага	16	18	2
3	АЖИЛЛАГСАДЫН ТОО	890	985	95
4	Удирдах ажилтан	57	60	3
5	Гүйцэтгэх ажилтан	250	296	46
6	Үйлчлэх ажилтан	450	496	46
7	Гэрээт ажилтан	133	133	0
8	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	890	985	95
9	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	199	203	4
10	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4	0
11	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	520	605	85
12	Гэрээт ажилтан	130	130	0
13	Улс төрийн албан хаагч (УТ)	37	42	5

Орон нутгийн төсвийн байгууллагын оны албан хаагчийн тоо тайлант онд 95 хүнээр нэмэгдсэн байна. Тайлант онд 2 байгууллага шинээр байгуулагдсантай холбоотой 47 албан хаагч, хог боловсруулах үйлдвэр ашиглалтад орохтой холбоотой Орхон аймгийн хот тохижуулах газарт 45 албан хаагч тус тус нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагын төрийн албан хаагчийн тоо өмнөх оноос 95 албан хаагчаар нэмэгдсэн байна. Энэ нь Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолд тусгагдсан “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ.” гэсэн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

2.2 Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны тайлангийн нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад 2,167.8 сая төгрөгөөр буюу 176.1 хувиар өссөн нь Хот тохижуулах газрын үйл ажиллагаанд хот доторх зам арчилгааны зардал, нийтийн тээвэр, хотын гэрэлтүүлгийн зардлууд нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан нь шалтгаалжээ.

Хүснэгт№9 Нэмэлт санхүүжилтийн зардлын гүйцэтгэл

№	Зардлын төрөл	2024 он	2025 он	/сая төгрөг/ Өсөлт + /бууралт-
1	Цалин хөлс, НДШ-ийн зардал	181.9	91.8	- 90.1
2	Байр ашиглалтын зардал	1.6	39.7	38.1
3	Хангамж, бараа материалын зардал	267.4	143.0	- 124.4
4	Норматив зардал	155.1	19.6	- 135.5
5	Урсгал засвар, эд хогшлын зардал	238.2	253.3	15.1
6	Томилолтын зардал	13.0	19.0	6.0
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамж	1,504.8	4,238.2	2,733.4
8	Бараа үйлчилгээний бусад зардал	73.0	68.7	- 4.3
9	Тэтгэмж урамшууллын зардал	413.7	143.2	- 270.5

	Нийт дүн	2,878.7	5,016.5	2,167.8
--	-----------------	----------------	----------------	---------

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн 8,827.4 сая төгрөгийн орлогоос 5,016.5 сая төгрөг зарцуулж, 3,811.0 сая төгрөгийн 881.7 сая төгрөгийг Баян-Өндөр сумын төсвийн орлогод 2,929.0 сая төгрөгийг аймгийн төсвийн орлогод, 602.5 сая төгрөгийг Хөгжлийн банканд тус тус төвлөрүүлжээ.

3. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРСЭН ҮР ДҮН, ТҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГЫГ ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

3.1 Аймгийн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний биелэлт 83.5 хувьтай хэрэгжилт хангажээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 03/13 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийг 2025 оны 07 дугаар сард тогтоолоор өөрчлөлт оруулж 172,329.3 сая төгрөг болгон 50,886.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

Хүснэгт№10 ОНХО-ын зардлын төлөвлөлт /аймаг/

				<i>/сая төгрөг/</i>
№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1	Шилжих хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	68	60,667.7	26,933.6
2	Шинэ хөрөнгө оруулалт	210	123,696.2	123,696.2
3	Төсөл, хөтөлбөр	155	14,050.6	14,050.6
	Дүн	433	212,465.1	172,329.3

Баян-өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийг 2025 оны 07 дугаар сард өөрчлөлт оруулж, 17,881.7 сая төгрөг болгон 8,035.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Хүснэгт№11 ОНХО-ын зардлын төлөвлөлт /Баян-Өндөр, Жаргалант сум/

				<i>/сая төгрөг/</i>
№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
<i>Баян-Өндөр сум/</i>				
1	Шилжих хөрөнгө оруулалт	6	2,008.0	860.7
2	Шинэ хөрөнгө оруулалт	27	8,244.4	8,244.4
3	Төсөл, хөтөлбөр	37	7,773.6	7,773.6
4	Байгаль хамгаалах арга хэмжээ	8	1,008.8	1,002.9
	Дүн	78	19,034.8	17,881.6
<i>Жаргалант сум</i>				
1	Шилжих хөрөнгө оруулалт	8	3,762.7	2,889.1
2	Шинэ хөрөнгө оруулалт	35	4,160.6	4,160.6
3	Төсөл, хөтөлбөр	7	276.0	276.0
	Дүн	50	8,199.4	7,325.8

Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 02/31 дүгээр тогтоолоор баталсан хөрөнгө оруулалтын төсвийг 2025 оны 07 дугаар

сард өөрчлөлт оруулж, 7,325.8 сая төгрөг болгон 158.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

Тайлант онд 152,727.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 486 төсөл арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1 дэх заалтын дагуу 155,506.3 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулж, төлөвлөгөөний биелэлт 83.5 хувьтай хэрэгжүүлжээ.

Хүснэгт№12 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр	ТАХ тоо	Төсөвт өртөг	/сая төгрөг/	
				Гэрээний дүн	Хэмнэлт + хэтрэлт-
1	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	202	90,390.9	61,003.1	29,387.8
2	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	17	21,253.3	20,333.1	920.2
3	Байгаль хамгаалах сан	20	4,260.8	2,922.9	1,337.9
4	Аймгийн авто замын сан	3	2,186.0	2,162.1	23.9
5	Орон нутгийн төсвийн шилжих хөрөнгө оруулалт	20	7,157.0	6,215.8	941.2
6	Эрдэнэт сан	6	500.0	472.7	27.3
7	Баян-Өндөр сумын ОНХС	95	10,905.0	9,268.1	1,636.9
8	Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалт	32	8,546.1	7,714.8	831.3
9	Байгаль хамгаалах сан	3	521.0	516.2	4.8
10	Жаргалант сумын ОНХС	88	7,007.4	4,897.5	2,109.9
Дүн		486	152,727.5	115,506.3	37,221.2

Аймгийн худалдан авах ажиллагааны газрын төлөвлөгөөнд 125.3 тэрбум төгрөгийн 266 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс Төрийн хэмнэлтийн хуулийн 13.1.1 дэх заалтын дагуу 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор 253 төсөл арга хэмжээ буюу төлөвлөгдсөн худалдан авалтын 95.1 хувийг зохион байгуулж, 212 төсөл, арга хэмжээний гэрээг байгуулж, 41 төсөл арга хэмжээ тендер зарлаад амжилтгүй болжээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас зураг төсөв ирээгүй 8 төсөл арга хэмжээ, 5 төсөл арга хэмжээний ажлын даалгавар ирээгүй нийт 13 төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалт явагдаагүй байна. Төлөвлөгөөний биелэлт 79.7 хувьтай хэрэгжилттэй байна.

Баян-Өндөр сумын Засаг даргын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 19.9 тэрбум төгрөгийн 132 ажил төлөвлөгдсөнөөс гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан 116, зураг төсөв ирээгүй 2, тендер шалгаруулалтыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1-д заасны дагуу зогсоосон 14 үүнээс амжилтгүй болсон 8 төсөл арга хэмжээ байна. Төлөвлөгөөний биелэлт 87.9 хувьтай байна.

Жаргалант сумын Засаг даргын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 7 тэрбум төгрөгийн 89 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан 76, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1-д заасны дагуу тендер шалгаруулалтыг зогсоосон 11, зураг төсөв ирээгүй 2 төсөл арга хэмжээ байна. Төлөвлөгөөний биелэлт 85.4 хувьтай хэрэгжүүлжээ.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хөтөлбөр арга хэмжээний хүрсэн үр дүн түүний танилцуулгыг тайлагнаагүй байна.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх 27 хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, өмнөх 2024 оноос 1 арга хэмжээ буюу Төрийн архив, албан хэрэг хөтлөлт арга хэмжээ нэмэгджээ.

Хүснэгт №13 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр	Жилийн төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
				Зөрүү	Биелэлт
1	70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	5,584.3	4,809.1	775.1	86.1
2	70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	170,098.6	74,190.4	95,908.2	43.6
3	70411 Төрийн архив, албан хэрэг хөтлөлт	306.4	137.67	168.78	44.9
4	70418 Худалдан авах ажиллагаа	608.00	458.95	149.05	75.5
5	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	734.21	671.60	62.61	91.5
6	70427 Төрийн нийтлэг бусад үйлч СШин	1,842.45	1,578.80	263.65	85.7
7	70429 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	671.90	632.96	38.94	94.2
8	70503 Орон нутгийн зорилтот ХОруулал	249,818.94	149,421.95	100,396.99	59.8
10	70709 Гэмт хэргээс урьдчилан сэргийл	600.00	499.28	100.72	83.2
11	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	100.80	90.20	10.60	89.5
12	71101 Авто зам	2,826.00	2,437.71	388.29	86.3
13	71302 Мэдээллийн нэгдсэн тогтол дэд	546.53	508.91	37.62	93.1
14	71403 Ойжуулалт	811.83	665.09	146.74	81.9
15	71411 Хүрээлэн буй орчны бодлого, уд	859.30	734.91	124.39	85.5
16	71413 Байгал орчин хамгаалан нехен сэргээх	5,624.94	3,277.88	2,347.06	58.3
17	71502 Хот байгуулалт, тохижилт	16,745.30	14,463.25	2,282.05	86.4
18	71509 БХБНААХуйн бодлого удирдлага	1,992.63	1,373.12	619.51	68.9
19	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,355.39	1,130.39	225.00	83.4
20	71701 Биеийн тамир спорт	35.30	34.13	1.17	96.7
21	71702 Соёл урлаг	452.14	358.95	93.19	79.4
22	71801 Сургуулийн өмнөх боловсрол	2,072.45	1,708.30	364.15	82.4
23	71802 Ерөнхий боловсрол	3,003.08	2,718.29	284.78	90.5
24	71804 Мэргэжлийн боловсрол	312.83	248.45	64.37	79.4
25	71806 Насан туршын болон албан бус боловсрол	119.00	115.94	3.06	97.4
26	71902 Нийгмийн халамж	192.51	149.89	42.62	77.9
27	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжи	793.45	428.56	364.89	54.0
Нийт дүн		468,108.3	262,844.7	205,263.6	56.2

Төсвийн нийт зардал 262,844.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 56.2 хувьтай байна.

Энэ нь:

- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэл 95,908.18 сая төгрөгөөр дутуу буюу 59.8 хувийн хэрэгжилттэй байгаа нь аймгийн болон сумдын Засаг дарга нарын эрхлэх хүрээний сангууд, Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар, Засаг дарга, Жаргалант сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын тамгын газруудын эрхлэх хүрээнд хамаарах дансдын гүйцэтгэл нөлөөлжээ.
- БХБНААХ бодлого удирдлага хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэл 619.5 сая төгрөг дутуу буюу 68.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Хот байгуулалт, барилга захиалагчийн алба, Хотын захирагчийн албаны цалингийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой байна.
- Төрийн архив, албан хэрэг хөтлөлт хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэл 168.8 сая төгрөгөөр дутуу буюу 44.9 хувийн хэрэгжилттэй байгаа нь аймгийн архивын хэлтсийг тайлант оны 8 сард байгуулсан бөгөөд шинээр байгуулахтай холбоотой үйл

ажиллагаа болон албан хаагчдын сонгон шалгаруулалт зэргээс шалтгаалан цалин хөлстэй холбоотой зардал хэмнэгдсэн байна.

- Байгал орчин хамгаалан нехен сэргээх хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэл 2,347.1 сая төгрөг дутуу буюу 58.3 хувийн хэрэгжилттэй байгаа нь Байгаль хамгаалах Сангийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3 арга хэмжээ хэрэгжээгүйтэй холбоотой байна.
- Орон нутгийн зорилтот Хөрөнгө оруулалт хөтөлбөр арга хэмжээний биелэлт 59.8 хувтай байгаа нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт арга хэмжээний 40 арга хэмжээний сонгон шалгаруулалт амжилгүй болж дараа онд шилжсэн, Сангийн яамнаас зарцуулах эрхийг хязгаарласантай холбоотой тайлант оны 9 дүгээр сараас зарлагын гүйлгээ дутуу хийгдэж хөрөнгө оруулалтын ажлуудын үлдэгдлийг 2026 оны төсөвт шилжих үлдэгдлээр тусгасан нь нөлөөлсөн байна.

Орхон аймгийн Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54.5.4¹д заасан бүрэлдэхүүн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсвийг ирүүлсэн бөгөөд хүрсэн үр дүн, түүний танилцуулга ирүүлээгүй байгаатай холбоотой хөтөлбөр арга хэмжээний биелэлтийг үнэлж, тайланд тусгах боломжгүй байна.

4. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙГ ХУГАЦААНААС НЬ ӨМНӨ ТӨЛЖ, АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАН АЖИЛЛАСАН БАЙНА.

4.1 "Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламж"-ийн өргөтгөлийн төслийн зээлийг хугацаанаас өмнө төлж дуусгасан байна.

БНФУ-ын хөнгөлөлттэй зээлээр хийгдэж буй "Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл" төслийн зээлийн төлбөрт 2022 онд 13,621.4 сая төгрөг, 2023 онд 1,225.9 сая төгрөг, 2024 онд 2,956.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс жил бүр төлж, тайланд онд 2,344.7 сая төгрөгийг шилжүүлэн 2030 оны 04 дүгээр сард төлбөрийг барагдуулах гэрээтэй төслийн зээлийг төлж дуусгасан байна.

4.2 Өмнөх оны аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

2024 оны Аймгийн Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар бүсчилсэн хөгжил, орлого төлөвлөлт болон орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой зөвлөж ний 5 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн биелэлтийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 08/ 3243 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 14. Аудитын зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	0	5	0	100.0
Албан шаардлага	-	-	-	-	-
Төлбөрийн акт	-	-	-	-	-

¹ хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/

Нийт дүн	5	0	5	0	100.0
-----------------	----------	----------	----------	----------	--------------

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Үүнд:

- Орхон аймгийн төсвийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан төлөвлөж байх гэсэн зөвлөмжийн хүрээнд "Хүний хөгжил", "Эдийн засгийн бодлого". "Аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө"- тэй уялдуулан боловсруулж, "Бүсчилсэн хөгжлийн бодлого"-д чиглэсэн 16 төсөл арга хэмжээнд 4.5 сая төгрөгийн төсөв тусгасан байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс урсгал зардлын шинжтэй төсөл арга хэмжээг төлөвлөж, зарцуулахгүй байх гэсэн зөвлөмжийн хүрээнд аймаг 54 арга хэмжээ, Баян-Өндөр сум 239 арга хэмжээ, Жаргалант сум 115 нийт 408 арга хэмжээг 14,609.1 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч салбар бүрээр хэлэлцүүлэг явуулж, ач холбогдлоор нь эрэмбэлэх аргачлалаар боловсруулсан бөгөөд зураг төсөв судалгааг үндэслэн төлөвлөсөн байна.
- Сумын татварын орлогыг бодитой төлөвлөж байх гэсэн зөвлөмжийн хүрээнд 2025 оны төсвийн тодотголоор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст, аймгийн Татварын газартай хамтран ажиллаж 12 нэр төрлийн орлого төвлөрүүлэхээр сумын ИТХ-аар батлуулсан байна. Татварын болон татварын бус орлогын төлөвлөсөн нийт дүн 160.188,6 сая төгрөгөөр тусгасан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

- 1.1 Аймгийн төсөвт 1 удаа тодотгол хийж, орлогыг анх батлагдсан дүнгээс 4,191.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, баталсан байна.
- 1.2 Тайлант онд аж ахуйн нэгж болон зарим татварын орлогыг бодитой төлөвлөөгүйгээс шалтгаалж нийт татварын орлого 24.2 хувиар тасарсан байна.
- 1.3 Орхон аймгийн Засаг дарга “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2024 оны дутуу санхүүжилт тайлант онд Эрдэнэт сангийн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой татварын бус орлого 68.9 хувиар давж биелсэн байна.
- 2.1 Орхон аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн зардлын хэрэгжилт 56.2 хувьтай байна.
- 2.2 Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
- 3.1 Аймгийн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний биелэлт 83.5 хувьтай хэрэгжжээ.
- 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хөтөлбөр арга хэмжээний хүрсэн үр дүн түүний танилцуулгыг тайлагнаагүй байна.
- 4.1 "Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламж"-ийн өргөтгөлийн төслийн зээлийг хугацаанаас өмнө төлж дуусгасан байна.
- 4.2 Өмнөх оны аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

- Орон нутгийн төсвөөс олгож буй орон нутагт ажилласны нэмэгдэл цалингийн санхүүжилтийг санхүүгийн жил дуусахаас өмнө тооцоо нийлж, үлдэгдлийг тайлант онд багтаан барагдуулж байх.
- Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолд тусгагдсан “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ.” гэсэн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.
- Аймгийн Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хөтөлбөр, арга хэмжээний хүрсэн үр дүн, түүний танилцуулгыг бэлтгэж байх.
- Гадаад арга хэмжээний зардлын хяналтыг сайжруулж, батлагдсан хөтөлбөр, хүрэх үр дүнтэй уялдуулж, хэмнэлттэй байдлаар зарцуулах.

Шалгагдагч байгууллагын санал



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
Цахим шуудан: info@erdenet.mn

2026.04.20 № 01/1488
танай _____ -ны № _____ -т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн асуудлын бүртгэлтэй танилцлаа. Аудитаас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн цаашид анхааран ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА

Б.ЗОРИГТБАЯР

6126093492